



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2017



Хүчтэй. Хамтдаа.



Агуулга

7	ТУЗ-ийн даргын илгээлт
9	Компанийн тухай
15	Хөрөнгийн зах зээлийн 2017 оны тойм
19	Үйл ажиллагааны тайлан
33	Таны сонирхолд
37	Хараат бус аудитын тайлан



Эрхэм зорилго

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг тодорхойлох анхдагч, манлайлагч байж, олон улсад нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банк болно.

Алсын хараа

Санхүүгийн зах зээлийн цогц үйлчилгээг иргэн бүрт хүргэж, Хөрөнгө Оруулагч Үндэстэн болоход мэргэжлийн зөвлөгч байна.



ТУЗ-ийн даргын илгээлт

Эрхэм хүндэт ТУЗ-ийн гишүүд, харилцагч, хувьцаа эзэмшигч, бизнесийн хамтрагчид аа,

2017 он хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын хувьд шинэ содон үйл явдлуудаар дүүрэн жил болж өнгөрлөө. Эдийн засгийн орчин оны эцэст сайжирч, төгрөгийн ханш чангарснаар иргэдийн итгэл даган нэмэгдэв. Үүний сацуу хөрөнгийн зах зээл дээр Сүү ХК-ийн нээлттэй бонд, Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК ба Жинст-Увс ХК-ийн урвуу нэгдэл, АПУ ХК-ийн бүтцийн өөрчлөлт, Ай Түүлс ХК-ийн IPO, “Ногоон сум” реалити шоу зэрэг шинэ бүтээгдэхүүн, сонирхолтой үйл явдлууд ар араасаа хөвөрч, үр дүнд нь иргэдийн мэдлэг дээшилж, уг зах зээлд шинээр хөл тавих боломжууд ч өргөнөөр нээгдлээ.

Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн хувьд 2017 онд хоёр удаа бүтцээ өөрчилж, хоёр удаа удирдлага нь солигдсоноор мөн л хөдөлгөөн ихтэй жил болов. Гэвч компанийн ТУЗ тухай бүрт хуралдаж холбогдох шийдвэр, үйл ажиллагааны чиглэлүүдийг гаргаж ажилласан билээ.

Толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдлийн нэгдсэн маркетинг, бодлого, бүтцийн хүрээнд бүх үйл ажиллагаа явагдаж, нэгдэл компани гэдэг утгаараа нэр хүнд, түүнтэй холбогдох зардлуудаа ч мөн адил хуваарилан ажиллав.


Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд компани нь гурван удаа төгрөгийн бонд, хоёр удаа долларын бонд гаргаж, нийт 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг хаалттай хүрээнд амжилттай босгов. Мөн бид Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг Монголын Хөрөнгийн Бирж дээр урвуу нэгдэл хийх замаар бүртгүүлсэн анхдагч амжилтын эзэн болсон юм.

Бид харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад тохирсон, өндөр өгөөжтэй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллахын сацуу иргэд, байгууллагуудад санхүүгийн боловсрол олгох сургалт, компанийн удирдлагуудад зориулан санхүүгээ хэрхэн оновчтой удирдах тухай сургалтыг зохион байгуулж, санхүүгийн өндөр мэдлэгтэй хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлж хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэхээр ажиллаж байна. 2017 оны дөрөвдүгээр сард Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулга уулзалтыг 1,000 гаруй оролцогчтойгоор зохион байгуулсан нь үүний нэг томоохон илрэл юм.

Цаашид бид залуу, чадварлаг хамт олныхоо хүчээр Монголын тэргүүлэгч брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани болох зорилго тавин ажиллах болно.

Хүндэтгэн ёсолсон,

П.БАТБАЯР



“

Хувьцаа гэдэг бол азын
сугалаа биш, харин бизнес
ээмших эрх гэдгийг
хүмүүс мартаx нь олонтаа.

Питер Линч



КОМПАНИЙН ТУХАЙ

Төлөөлөн Удирдах Зөвлөл



Пүрэвжаргал **Батбаяр**
ТУЗ-ийн дарга



Чулуун **Ганхуяг**
Гүйцэтгэх захирал
Ард Санхүүгийн
Нэгдэл ХК



Галбадрах **Цогбадрах**
Гүйцэтгэх захирал
Ард Даатгал ХХК



Аръяасүрэн **Батболд**
Үйл ажиллагаа
хариуцсан захирал
Ард Даатгал ХХК



Чулуун **Ганзориг**
Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ

Компанийн бүтэц



Компанийн түүх

Батс Инвест брокер дилерийн эрхтэйгээр үүсгэн байгуулагдав. Брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах албан ёсны эрхээ авав.

1997

2007

Андеррайтерийн тусгай зөвшөөрөл авав.

Хаалттай хүрээнд анхны компанийн бонд гаргав.

2008

2009

Компанийн нэр Монет ХХК болж өөрчлөгдөв. СЗХ-оос хөрөнгө оруулалтын зөвлөхийн эрх авав.

Компанийн нэр Монет Капитал ХХК болж өөрчлөгдөв.

2012

2014

МТНД ХХК, И АЙ ТИ ХХК, ТОСК ХХК, Промон трейд ХХК-д хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг тус тус үзүүлэв.

Ард Секьюритиз УЦК ХХК болгон нэрээ өөрчлөв.

2015

2017

ХОУ ХК-ийн урвуу нэгдэлд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, хаалттай хүрээнд таван компанийн бондыг амжилттай гаргав.

Бүтээгдэхүүн үйлчилгээ



45%

Үнэт цаасны зах зээл

- Үнэт цаасны данс нээх
- Үнэт цаасны арилжаанд зуучлах
- Нээлттэй болон хаалттай зах зээлд өрийн бичиг арилжих
- Үнэт цаас барьцаалсан зээлийн үнэлгээ гаргах



35%

Андеррайтинг

- Нээлттэй болон хаалттай компанийн бонд гаргах
- Анхдагч зах зээл дээр үнэт цаас гаргах
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах



20%

Хөрөнгө оруулалтын зөвлөгөө


- Санхүүгийн болон үйл ажиллагааны дүн шинжилгээ
- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ



“

Хөрөнгийн зах зээл болон
цаг агаар хоёр олон
талаараа төсөөтэй. Хэрэв
танд одоогийн нөхцөл
байдал таалагдахгүй байгаа
бол хэсэг хугацаанд хүлээж
байдлыг ажихаас өөр арга
танд үгүй.

Лоу Симпсон




ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2017 ОНЫ ТОЙМ

Хөрөнгийн зах зээл

Зах зээлийн үнэлгээ 2017 оны байдлаар Монголын Хөрөнгийн Бирж ХК болон Монголын Үнэт Цаасны Бирж ХХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээний нийлбэр дүн 2,440.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 966.1 тэрбум төгрөг буюу 65.5 хувиар өссөн үзүүлэлт юм.


Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулж тооцсон, хөрвөх чадварын үзүүлэлт нь 3.2 хувь байна.

Хөрвөх чадварын түвшин



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Голлох тоон үзүүлэлтүүд

19,554

Шинээр данс нээсэн иргэн, ААН

Хувьцааны анхдагч
зах зээлийн арилжаа

1.3 тэрбум

10.2 тэрбум

Нээлттэй бондын арилжаа

Хувьцааны хоёрдогч
зах зээлийн арилжаа

75.1 тэрбум

772.5 тэрбум

ЗГҮЦ-ны арилжаа

9

I ангиллын ХК

41

II ангиллын ХК,

168

III ангиллын ХК

12 ХК

I Төрийн оролцоотой

19 ХК

I Төрийн өмчит

187ХК

I Хувийн өмчит



“



Хувьцааг сэтгэл хөдлөл дээр
бус тооцоололд суурилж
худалдан ав.

Бенжамин Грэхэм







ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


Тоон үзүүлэлтүүд




сая төгрөгөөр




Харилцагчийн тоо




Шинэ данс



Нийт захиалгын тоо



Данс нээсний орлого



Шимтгэлийн орлого

240

Харилцагчийн хүсэлтээр
ногдол ашгийн гүйлгээ хийсэн

40

Хүний хүсэлтээр 6634.1 сая төгрөгийн
бондын эргэн төлөлт хийсэн

2017 онд гаргасан өрийн бичиг

• 2016 оны
12 сар



\$600,000

Хүннү Эйр компани нь
Гадаад худалдаа,
арилжааны агаарын
тээврийн үйл ажиллагаа
эрхлэгч Хүннү Эйр компани.

• 5 сар



₮2 тэрбум

Орчин үеийн дэвшилтэт аргачлалыг
ашиглан бичил болон жижиг зээлийн
үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай
хүргэгч Ард Кредит ББСБ.



₮2 тэрбум

Санхүүгийн салбарт үйл ажиллагаа
явуулж буй манлай компаниудад
хөрөнгө оруулалт хийж, хувь
нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт
тавин ажиллаж байгаа үндэсний
санхүүгийн холдинг компани

• 2 сар

10 сар

ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

\$250,000

Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани

 **NATIONAL**
ARMY-SECURITY PROJECT
N.A.P. GROUP

₮350 сая

Хот төлөвлөлтийн баримт бичгүүд, барилга, байгууламжийн эх загвар болон ажлын зураг төслийг боловсруулан гүйцэтгэгч ЭН ЭЙ ПИ компани.

10 сар

Хөрөнгө Оруулалтаа Амилуулах Аян

1990 оны өмч хувьчлалд мэдлэг, мэдээлэлтэй орж чадаагүй, хувьцаандаа хяналт тавьж, хөрөнгө оруулалтаа амьд байлгаж чадаагүй болон төрийн өмчийн хувьчлалд мэдлэг, мэдээлэлтэй хөрөнгө оруулалт хийхээр зорьж буй иргэдэд зориулсан "Хөрөнгө оруулалтаа амилуулах аян"-г Улаанбаатар болон Эрдэнэт хотуудад тус тус зохион байгуулсан.

Ерэн оны өмч хувьчлалаар цэнхэр, ягаан тасалбар авч, томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьцаа эзэмшигч болсон 250 мянга орчим иргэн ногдол ашиг болон ногдол хувиа хөдөлгөөнд оруулалгүй явснаар уг хөрөнгийн төвлөрөл 8 тэрбум орчим төгрөг болсон ба иргэд ямар компанийн хувьцаа авсанаас хамаарч нэг хүнд 10 мянгаас 10 сая

хүртэлх төгрөгийн ногдол ашиг хуримтлагдсан байдаг. Ард Секюритиз ҮЦК-аас 2017 онд "Хөрөнгө оруулалтаа амилуулах аян"-д оролцолчдод энэ талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, дансыг нь шүүн, хуримтлагдсан ногдол ашгаа авах боломжоор ханган ажилалаа.

Тус аянаар мөн "Хөрөнгө оруулалтын сонголтыг хэрхэн хийх вэ?", "Хувьцаа ямар ашигтай вэ?", "Үнэт цаас гаргагч компаниудын зүгээс хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хамгаалдаг вэ?", "Хөрөнгө оруулагч үндэстэн болохын ач холбогдол", "Өмч хувьчлал - өнгөрсөн ба ирээдүй" зэрэг сэдэвтэй илтгэлүүд танилцуулагдсан билээ.



Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулга Уулзалт

Бид Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулга уулзалтыг:

- Санхүү, хөрөнгийн зах зээлийн шилдгийн шилдгүүдийг нэг дор цуглуулан, Монголын хамгийн том хөрөнгө оруулалтын чуулганы үндсийг тавих
 - Монголын эдийн засгийн байдал, санхүү, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн орчин нөхцөлийн талаар хэлэлцэх
 - Эдийн засаг дахь банк санхүү болон хөрөнгийн зах зээлийн тэнцвэртэй хөгжлийг бий болгох
 - Финтек гэж юу болох тухай, түүний ач холбогдлын талаар танилцуулах
 - Санхүүгийн боловсрол олгон мэдлэгтэй хөрөнгө оруулагч үндэстэнг бий болгох, хөрөнгө оруулалтын боломжуудыг танилцуулах
- зорилготойгоор 4 сарын 22,23-нд зохион байгуулж, 1,000 гаруй иргэнийг нэг дор цуглуулж чадсан юм.



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН
ЧУУЛГА УУЛЗАЛТ

Ард Академи

Ард Академи санхүүгийн боловсролын төв нь 2016 оноос үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, нийт 3,000 гаруй харилцагчдадаа анхан болон дунд шатны сургалтыг хүргэн ажиллаж байна.

Оновчтой хөрөнгө оруулалт, компанийн засаглал болон эрсдлийн үнэлгээний суурь зарчмын тухай ойлголтыг танхимын сургалтаар дамжуулан хүргэж харилцагчдынхаа санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, мөн компанийн бэлтгэн гаргадаг мэргэжлийн судалгаа шинжилгээнд дүгнэлт хийн оновчтой шийдвэр гаргаж хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг нь тэдэнд нээн өгч байна.



Хүчтэй. Хамтдаа.

ХУВИЙН САНХҮҮ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

АНХАН ШАТНЫ СУРГАЛТ



ХУВИЙН САНХҮҮ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



ХУВЬЦАА АРИЛЖАА



БИТКОЙН, ЦАХИМ АЛТ



ХАЯГ: АРД САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН БАЙР, 2 ДАВХАР
УТАС: 321899
W3W: ЦЭНЭГ.ЭРДЭМТЭЙ.ӨНГӨЛӨХ

Ардын цахим мэдээ

Хөрөнгийн зах зээл дээр өрнөж буй шинэ соргог үйл явдлуудын тухай мэдээ мэдээллийг агуулсан Ард Ньюс нь долоо хоног бүр манай харилцагчдын цахим хаягаар хүрч байна.

Гадаад болон дотоодын хөрөнгийн зах зээл дээр өрнөж буй үйл явдлуудын тухай мэдээ мэдээллээс гадна Монголын хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа идэвхтэй арилжаалж буй компаниудын санхүүгийн шинжилгээ, хувьцааны үнэ ханшийн савалгаа зэрэг мэдээллийг харилцагчид маань цаг тухайд нь авах боломжтой.

Ном, хэвлэл



Миний анхны амжилттай
хөрөнгө оруулалт
2017.4.22



Цахим алт
Биткойн, Криптовалют, Блокчэйн
2017.10.31

Ногоон Сум

Иргэд, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох тухай мэдээллийг олон нийтэд богино хугацаанд сонирхолтой, үр дүнтэйгээр хүргэх үүднээс Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нь MYONPT-тэй хамтран “Ногоон сум” реалити шоу-г зохион байгуулж ажиллалаа.

Уг реалити шоу нэвтрүүлэгт хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож байгаагүй олон нийтийн төлөөлөл болох 5 оролцогч оролцсон бөгөөд мэргэжлийн зөвлөх байгууллагуудаас зөвлөгөө авсны үндсэн дээр нийт 5 сая төгрөгөөр Монголын Хөрөнгийн Бирж дээрээс үнэт цаас худалдан авч оролцсон юм.




Улаанбаатар чуулгын бүжигчин Б.Ганчимэг II байр




“Ногоон сум” шоуны хамт олон

Хөрөнгө оруулалтын өгөөж



Хөрөнгө оруулалтын багц



Нийгмийн хариуцлага

Ard Champions

Оюутан залуусын боловсролыг дэмжих, шилдэг боловсон хүчинг бэлдэх зорилготой Ard Champions уралдааныг зарлав.




Ард Академи - Хөдөө орон нутгаар

Эрдэнэт, Чойр, Сайншанд, Замын-Үүд, Хэнтий, Багануур хотуудын 1,338 хүнд хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэг олох сургалтыг зохион байгуулав.

Дуулиан 2020

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн нэрэмжит “Дуулиан-2020”-нд оролцогч 72-р сургуулийн баг хамт олныг ивээн тэтгэв.



Ard Volunteer

Оюутан залуусын сурч байх хугацаандаа дадлагажих боломжийг хангах үүднээс тасралтгүй сургалт, дадлагын хөтөлбөрүүдийг явуулав.

Тайлант үеийн дараах үйл явдал

2018 оны эхний улиралд Ард Секюритиз нь 968 иргэний дансыг нээж, 277 иргэн, аж ахуйн нэгжийг анхдагч зах зээлийн арилжаанд зуучлав.

Бид эхний улирлын сүүлийн 7 хоногт Монголын тэргүүлэгч ББСБ-ын нэг болох Нэткапитал Финанс Корпорацийн хаалттай хүрээний өрийн бичгийн андеррайтераар ажиллалаа. Гурав болон зургаан сарын хугацаатай нийт 2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэх ёстойгоос эхний улиралдаа 1.5 тэрбум төгрөгийг нь босгож чадсан юм.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компани Ард Кредит ББСБ, Ард Даатгал ХХК нь 2018 ондоо багтаан IPO буюу хувьцаагаа нээлттэй арилжихаар төлөвлөж буй бөгөөд Ард Секюритиз ҮЦК туслах андеррайтераар ажиллахаар төлөвлөж байна.






“

Хөрөнгийн зах зээл гэдэг
бол тэвчээргүй нэгнээс
нь авч, тэвчээртэйд нь
шилжүүлж өгөх л үйл явц
юм.

Уоррен Баффет

ТАНЫ
СОНИРХОЛД

Цэнхэр, ягаан тасалбар болон Эрдэнэс Таван Толгойн хувьцаа



1991-1994 оны хувьчлалаар нийт 250 мянган иргэнд цэнхэр, ягаан тасалбарыг тараасан байдаг.


Цэнхэр тасалбар нь өмч хувьчлалын үед 7,000 төгрөгийн үнэ ханштай, үйлдвэрийн газар хувьчилж авах зориулалттай байв.

Ягаан тасалбар нь 3,000 төгрөгийн өртөгтэй, үйлчилгээ, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан компаниудын хувьцааг худалдаж авах эрхтэй байжээ.

Монгол Улсын Засгийн газар 2012 онд **“Эрдэнэс Таван Толгой”** ХК-ийн нийт хувьцааны 20 хувь болох 3 тэрбум ширхэг хувьцааг 2012 оны 4 сарын 11-нээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэн бүрт үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр болсон.

ЦЭНХЭР, ЯГААН ТАСАЛБАР БОЛОН “ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙН” ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ЭСЭХЭЭ ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ?

Ягаан, цэнхэр тасалбартай эсэхээ шалгахын тулд эхлээд та үнэт цаасны данстай эсэхээ шалгах хэрэгтэй. Тухайн үед та тасалбараа баталгаажуулсан бол данстай байна гэсэн үг. Данстай эсэхээ шалгахын тулд net.schcd.mn цахим хуудас руу нэвтрэх боломжтой.



Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?

Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг (бонд), компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсвэл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа зэргийг нийтэд нь **үнэт цаас** гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, үнэт цаас гэдэг нь таныг тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн юм уу, зээл олгосон гэдгийг гэрчлэх баримт юм. Үнэт цаасны ашиг, эрсдлийн түвшин нь банкны хадгаламжийг бодвол харьцангуй өндөр байдаг бөгөөд худалдах, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлэх боломжтойгоороо онцлогтой.

Манай улсын үнэт цаасны зах зээл дээр бонд, хувьцаа гэсэн хоёр төрлийн үнэт цаас арилжаалагдаж байна.

Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?

1.

**Үнэт цаасны
данстай эсэхээ
шалгана.**

2.

**Брокерын
компаниа сонгоно.**

3.

**Үнэт цаас болон
арилжааны данс
нээлгэнэ.**

4.

**Арилжааны
дансандаа мөнгөө
байршуулна.**

5.

**Худалдан авах
үнэт цаасаа
сонгоно.**

6.

**Брокертоо
худалдан авах
захиалгаа өгнө.**

Хувьцаа барьцаалсан зээл

ARD КРЕДИТ
ББСБ

ARD СЕКЮРИТИЗ
ҮЦК



ХУВЬЦАА БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ

- Зээлийн нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагагүй
- 1 цагийн дотор зээлээ авах боломжтой
- Бусад шуурхай зээлүүдтэй харьцуулахад хүү бага
- Өөрийн эзэмшлийн хувьцаагаа заралгүйгээр бэлэн мөнгө авна
- Барьцаалах хугацаанд ноогдол ашиг/өгөөжөө авна



АУДИТЫН ТАЙЛАН

“АРД СЕКЬЮРИТИЗ” ХХК -ИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Секьюритиз ҮЦК” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Секьюритиз ҮЦК” ХХК -ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг

тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид

санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

• Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ДАЛАЙВАН АУДИТ ХХК

УЛААНБААТАР ХОТ 2018 ОНЫ 03 ДУГААР

МОНГОЛ УЛС САРЫН 16-НЫ ӨДӨР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31.	2016.12.31.
ХӨРӨНГӨ			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	5.1	112,736.2	219,752.3
Худалдааны ба бусад авлага	5.2	118,051.4	230,654.5
Арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө	5.3	315,843.6	212,136.2
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	5.3	2,734,966.6	2,336,625.8
Урьдчилж төлсөн тооцоо	5.5	19,457.9	3,957.2
Нийт эргэлтийн хөрөнгө		3,301,055.7	3,003,126.0
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө /цэвэр/	5.6	156,457.5	173,940.1
Биет бус хөрөнгө /цэвэр/	5.7	7,859.9	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5.3	24,000.0	12,097.0
Нийт эргэлтийн бус хөрөнгө		188,317.4	186,037.1
НИЙТ ХӨРӨНГӨ		3,489,373.1	3,189,163.1
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат санхүүгийн түрээсийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	5.4	34,470.6	31,326.0
Богино хугацаат зээл	5.4	11,097.3	20,000.0
Худалдааны болон бусад өглөг	5.4	988,467.3	844,914.3
ААНОАТ-н өглөг	5.8	938.5	24,531.5
Бусад татвар, шимтгэлийн өглөг	5.8	8,585.2	3,722.2
Хүүний өглөг	5.4	5,207.4	
Нийт богино хугацаат өр төлбөр		1,048,766.3	924,494.0
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат зээл	5.4	151,547.5	431,249.1
Урт хугацаат санхүүгийн түрээс	5.4	87,907.2	110,126.5
Хойшлогдсон татварын өглөг	5.8	55,702.4	
Нийт урт хугацаат өр төлбөр		295,157.1	541,375.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,343,923.4	1,465,869.6
Өмч			
Хувьцаат капитал	5.9	2,001,956.0	2,001,956.0
Нэмж төлөгдсөн капитал	5.9	190,491.3	190,491.3
Хуримтлагдсан ашиг, алдагдал	5.9	(548,319.2)	(469,153.8)
Эздийн өмчийн бусад хэсэг	5.9	501,321.6	
Нийт өмч		2,145,449.7	1,723,293.5
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		3,489,373.1	3,189,163.1

ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31.	2016.12.31.
Үндсэн үйл ажиллагааны орлого	5.10	395,966.3	547,405.0
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	5.11	(474,362.9)	(295,143.2)
Санхүүгийн орлого, зардал	5.12	(14,299.5)	(74,312.0)
Үйл ажиллагааны бус орлого, зардал	5.13	14,466.7	19,500.0
Бусад олз, гарз			(3,022.2)
Татвар төлөхийн өмнөх ашиг		(78,229.4)	194,427.6
Орлогын албан татварын зардал	5.14	(935.9)	(19,073.9)
Тайлант жилийн цэвэр ашиг		(79,165.3)	175,353.7
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөц	5.9	501,321.6	
Дэлгэрэнгүй ашиг, (алдагдал)		<u>422,156.3</u>	

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	(мянган тогроогоор)		
			Хөрөнгө оруулалтын үнэлгээний ноц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	501,961.0	190,491.2		(644,507.5)	47,944.7
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					
Залруулагдсан үлдэгдэл	501,961.0	190,491.2		(644,507.5)	47,944.7
Нэмж гаргасан энгийн хувидаа	1,499,995.0				1,499,995.0
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)				175,353.7	175,353.7
Бусад дэлгэрэнгүй орлого					
Зарласан ногдол ашиг					
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,001,956.0	190,491.2		(469,153.8)	1,723,293.4
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					
Залруулагдсан үлдэгдэл	2,001,956.0	190,491.2		(469,153.8)	1,723,293.4
Нэмж гаргасан энгийн хувидаа					
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)				(79,165.3)	(79,165.3)
Бусад дэлгэрэнгүй орлого			501,321.6		501,321.6
Зарласан ногдол ашиг					
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,001,956.0	190,491.2	501,321.6	(548,319.1)	2,145,449.7

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

	(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	2017.12.31.	2016.12.31.
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг/алдагдал	(78,229.4)	194,427.0
<i>Тохируулга:</i>		
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын олз/гарз	(89,423.4)	(5,519.0)
Элэгдэл хорогдлын зардал	20,925.5	33,220.0
Хүүгийн орлого	(9,359.1)	(39,730.0)
Ногдол ашгийн орлого	(544.6)	
Хүүгийн зардал	117,117.6	96,648.0
Бусад мөнгөн бус орлого	(6,699.7)	
Данснаас хассан өмч, тоног төхөөрөмж		19,989.0
Урт хугацаат санхүүгийн түрээсийн ханшийн зөрүү	(4,862.5)	17,291.0
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	(51,075.6)	316,326.0
Худалдааны ба бусад авлагын өөрчлөлт	113,902.8	(196,285.0)
Бусад хөрөнгийн өөрчлөлт	(15,500.7)	(3,336.0)
Худалдааны ба бусад өглөгийн өөрчлөлт	(803,631.7)	(3,218,775.0)
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлт	(705,229.6)	(3,418,396.0)
Төлсөн орлогын татвар	(18,312.1)	(386.0)
Хүлээн авсан хүү	9,359.1	39,730.0
Төлсөн хүү	(111,910.2)	(45,534.0)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон цэвэр мөнгөн гүйлгээ	(877,168.3)	(3,108,260.0)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө	(1,292,019.4)	(179,791.0)
Худалдсан санхүүгийн хөрөнгө	2,360,564.7	3,083,009.0
Худалдан авсан үндсэн болон биет бус хөрөнгө	(12,439.4)	(4,417.0)
Худалдсан үндсэн болон биет бус хөрөнгө		2,017.0
Хүлээн авсан ногдол ашиг	544.6	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,056,650.5	2,900,818.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Авсан зээл	87,748.0	431,970.0
Зээлийн төлөлт	(374,246.2)	(63,635.0)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(286,498.2)	368,335.0
Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(107,016.1)	160,893.0
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн эхний үлдэгдэл	219,752.2	58,859.0
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн эцсийн үлдэгдэл	112,736.2	219,752.0

ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн
байгууллага



Брокер, диллер, андеррайтер
хөрөнгө оруулалтын зөвлөх



Тэтгэврийн сан



Хадгаламж зээлийн
хоршоо



Хөрөнгө оруулалтын
менежмент



Хөрөнгө оруулалтын сан



Криптовалютын арилжаа



Санхүүгийн сургалт



Шуудангийн цогц
шийдэл



Санхүүгийн програм хангамж



Үл хөдлөх хөрөнгийн
түрээс

